

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн “Ундарга-Алтай” аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2025 оны  
санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ГАА-2026/011/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Алтай хот  
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: [gunjidmaag@audit.gov.mn](mailto:gunjidmaag@audit.gov.mn)

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: [erdenechimegd@audit.gov.mn](mailto:erdenechimegd@audit.gov.mn)

Ахлах аудитор: Д.Цэрэнханд

Утас: 99086371 Цахим хаяг: [tserenkhandd@audit.gov.mn](mailto:tserenkhandd@audit.gov.mn)

Аудитор: Н.Гэрэлмаа

Утас: 99782918 Цахим хаяг: [gerelmaan@audit.gov.mn](mailto:gerelmaan@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

---

**АГУУЛГА**

---

<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН</b> .....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр).....	3
Гурав. Аудитын илрүүлэлт .....	7
3.1 Залруулсан алдаа: .....	7
3.3 Албан шаардлага .....	8
3.4 Зөвлөмж.....	10
<b>Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	12

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар



## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091  
Утас: (976) 70 48 34 13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026.03.13 № 128

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

“УНДАРГА-АЛТАЙ” АЖ АХУЙН  
ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ Э.ЭНХБОЛД ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Ундарга-Алтай” аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр “Хязгаарлалттай” санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв илэрхийлсэн байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй. Үүнд:

- Байгууллагын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөнд 4,049,957.7 мянган төгрөгийн борлуулалтын орлого төлөвлөсөн боловч 1,526,335.8 мянган төгрөгийн орлого тасарч, 588,447.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж, тайлант оны зорилтот түвшинд батлаагүй байхад байгууллагын төсвөөс баруун бүсийн ажил мэргэжлийн уралдаан, тэмцээн, зөвлөгөөнд 1,752.0 мянган төгрөг, ажилчдын баярт 2,324.0 мянган төгрөг нийт 4,076.0 мянган төгрөгийг бэлэг дурсгалын зүйлд зарцуулсан,
- Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшний төлөвлөгөөнд тусгаагүй 10,000.0 мянган төгрөгийн тавилга бэлтгэсэн,

822505000390

- Санхүүгийн тайланд тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байгууллага, хувь хүнтэй холбоотой 1,059,765.3 мянган төгрөгийн авлага, 241,966.3 мянган төгрөгийн өр төлбөр тусгасан,
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор 214,325.0 мянган төгрөгийн 5 үндсэн хөрөнгийг актлах шийдвэр гарсан боловч 7,856.4 мянган төгрөгийн 1 хөрөнгийг актлаагүй,
- Тайлант онд гэрээгээр хийгдсэн 211,999.1 мянган төгрөгийн 8 ажлын гүйцэтгэлийг хүлээн авсан боловч, хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй,
- Байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй,
- Ундарга-Алтай аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2022, 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 06/250, 01/104 дугаартай 17,108.3 мянган төгрөгийн шүүхийн шийдвэрээр олгосон цалингийн нөхөн олговортой холбоотой 2 албан шаардлагыг төлүүлэх арга хэмжээ аваагүй,
- Нэгээс жилийн насжилттай он дамнасан авлагыг барагдуулах талаар арга хэмжээ аваагүй, тайлант онд 13,299.0 мянган төгрөгийн тавилга, багаж бэлтгэсэн боловч цахим дэлгүүрээс худалдан аваагүй зэрэг зөрчлийг давтан гаргасан, 1,243,906.1 мянган төгрөгийн авлага, 4,775,449.1 мянган төгрөгийн өр төлбөртэй ажилласан байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.5.7, 41 дүгээр зүйлийн 41.2.1, 41.2.2, 41.2.7, 24 дүгээр зүйлийн 24.4 дэх заалтууд, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2.1, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3, 70 дугаар зүйлийн 70.2, 72.1 дэх заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4, 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь заалт, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Орон нутгийн төсвийн 125,499.1 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтаар Есөнбулаг сумын ус хангамжийн эх үүсвэрийн генератор холбох ажил, 364,000.0 мянган төгрөгийн 7 ус түгээх байр, автомат худгийг тус тус хүлээн авч ашиглалтад оруулсан байна.

Тайлант онд байгууллагын хөрөнгөөр 16,299.0 мянган төгрөгийн тавилга, компьютер, тоног төхөөрөмж бэлтгэж, байгууллагын гадна, дотор засварын ажилд 14,887.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### **Аудитын гол асуудал**

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 32 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар Ундарга-Алтай аж ахуйн тооцоот үйлдвэрийн

газрын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөнд нийт орлогыг 4,049,957.6 мянган төгрөгөөр, нийт зардлыг 4,035,625.6 мянган төгрөгөөр буюу 14,332.0 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар баталж, гүйцэтгэлээр 1,526,335.8 мянган төгрөгийн орлого тасарч, 588,447.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

### **Бусад асуудал**

Тайлант онд 8 зорилтын хүрээнд 26 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 22 арга хэмжээ бүрэн буюу 100.0 хувь, 2 арга хэмжээ 90.0 хувь, 2 арга хэмжээ 70.0 хувиар, нийт дүнгээр 96.0 хувиар биелүүлж, биелэлтийг аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн боловч ажлыг үнэлээгүй байна.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР  Т.ГҮНЖИДМАА



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Эхний үлдэгдэл	2. Эцсийн үлдэгдэл
1	1.1 ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,033,237,367.93	1,386,112,599.12
31	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	67,911,383.45	25,111,878.55
31100	1.1.1.01 Кассанд байгаа бэлэн мөнгө	8,496,610.00	3,791,940.91
31110	1.1.1.01.01 Төгрөг	8,496,610.00	3,791,940.91
31200	1.1.1.02 Банкинд байгаа бэлэн мөнгө	59,414,773.45	21,319,937.64
31210	1.1.1.02.01 Төгрөг	59,414,773.45	21,319,937.64
31213	1.1.1.02.01.03 Арилжааны банк дахь харилцах	59,414,773.45	21,319,937.64
33	1.1.3 АВЛАГА	933,659,284.42	1,243,906,066.40
33401	1.1.3.05 Дансны авлага /ТӨҮГ/	915,270,947.42	1,089,618,787.40
33500	1.1.3.07 Бусад авлага	18,388,337.00	154,287,279.00
33520	1.1.3.07.02 Хувь хүмүүсээс авах авлага	18,388,337.00	154,287,279.00
35	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	31,666,700.06	117,094,654.17
35100	1.1.5.01 Түүхий эд материал	2,186.46	2,186.46
35110	1.1.5.01.01 Тусгай зориулалттай материал	2,186.46	2,186.46
35300	1.1.5.03 Бэлэн бүтээгдэхүүн	10,192,150.00	10,192,150.00
35400	1.1.5.04 Хангамжийн материал	21,472,363.60	106,900,317.71
35410	1.1.5.04.01 Бичиг хэргийн материал	-	754,545.45
35420	1.1.5.04.02 Аж ахуйн материал	21,472,363.60	96,881,317.72
35430	1.1.5.04.03 Сэлбэг хэрэгсэл	-	9,264,454.54
2	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,469,810,521.94	5,081,466,758.71
39	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,469,810,521.94	5,081,466,758.71
39200	1.2.2.02 Биет хөрөнгө	5,428,786,782.65	5,040,640,765.50
39201	1.2.2.02.01 Барилга, байгууламж, орон сууц	7,221,066,956.65	7,014,597,556.65
39202	1.2.2.02.02 Хуримтлагдсан элэгдэл	(2,341,730,056.02)	(2,478,743,447.57)
39203	1.2.2.02.03 Авто-тээврийн хэрэгсэл	763,793,595.66	763,793,595.66
39204	1.2.2.02.04 Хуримтлагдсан элэгдэл	(343,714,152.54)	(376,166,658.84)
39205	1.2.2.02.05 Машин тоног төхөөрөмж(компьютер)	287,990,295.36	287,990,295.36
39206	1.2.2.02.06 Хуримтлагдсан элэгдэл	(192,505,091.42)	(206,469,308.92)
39207	1.2.2.02.07 Тавилга, аж ахуйн эд хогшил	28,564,116.35	39,863,116.35
39208	1.2.2.02.08 Хуримтлагдсан элэгдэл	(22,284,724.33)	(26,118,140.89)
39214	1.2.2.02.14 Бусад үндсэн хөрөнгө	43,202,273.47	45,202,273.47
39215	1.2.2.02.15 Хуримтлагдсан элэгдэл	(15,596,430.53)	(23,308,515.77)
39300	1.2.2.03 Биет бус хөрөнгө	41,023,739.29	40,825,993.21
39303	1.2.2.03.03 Бусад биет бус хөрөнгө	66,646,154.06	66,646,154.06
39304	1.2.2.03.04 Хуримтлагдсан элэгдэл	(25,622,414.77)	(25,820,160.85)
3	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	6,503,047,889.87	6,467,579,357.83
4	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,222,470,480.60	4,775,449,150.07
41	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	426,607,852.12	769,613,860.05
41300	2.1.1.03 Өглөг	426,607,852.12	769,613,860.05
41360	2.1.1.03.06 Бусад өглөг	426,607,852.12	769,613,860.05
41363	2.1.1.03.06.03 Татварын өглөг /ТӨҮГ/	81,620,908.50	37,091,981.49
41366	2.1.1.03.06.06 Дансны өглөг /ТӨҮГ/	344,986,943.62	732,521,878.56
42	2.1.2 УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,795,862,628.48	4,005,835,290.02
42200	2.1.2.02 Урт хугацаат зээл	3,795,862,628.48	4,005,835,290.02
42210	2.1.2.02.01 Төгрөг	3,795,862,628.48	4,005,835,290.02
42211	2.1.2.02.01.01 Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	3,795,862,628.48	4,005,835,290.02

5	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,280,577,409.27	1,692,130,207.76
51	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	2,280,577,409.27	1,692,130,207.76
51100	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал	3,413,450,457.62	3,413,450,457.62
511002	2.2.1.01.02 Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	3,413,450,457.62	3,413,450,457.62
51200	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	(1,192,633,463.32)	(1,781,080,664.83)
51210	2.2.1.08.01 Өмнөх үеийн үр дүн	(1,398,766,723.48)	(1,192,633,463.32)
51220	2.2.1.08.02 Тайлант үеийн үр дүн	206,133,260.16	(588,447,201.51)
51300	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	59,760,414.97	59,760,414.97
6	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	6,503,047,889.87	6,467,579,357.83

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
I	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	495,233,167.16	118,638,167.29
12	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	495,233,167.16	118,638,167.29
120	1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	495,233,167.16	118,638,167.29
120010	1.1.1.04.1.10 Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	2,638,010,731.66	2,523,654,615.89
120011	1.1.1.04.1.11 Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	2,292,777,564.50	2,498,040,312.57
120017	1.1.1.04.1.13 Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	150,000,000.00	93,023,863.97
II	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	289,099,907.00	707,085,368.80
21	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	289,099,907.00	707,085,368.80
210	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	289,099,907.00	707,085,368.80
2108	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	289,099,907.00	707,085,368.80
210811	1.1.2.01.1.08.11 Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	223,230,532.75	442,780,631.38
210813	1.1.2.01.1.08.13 Бусад зардал /ТӨҮГ/	42,965,678.68	2,815,988.00
210814	1.1.2.01.1.08.14 Орлогын татварын зардал /ТӨҮГ/	22,903,695.57	261,488,749.42
III	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	206,133,260.16	(588,447,201.51)
VI	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	206,133,260.16	(588,447,201.51)

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
I	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,442,742,959.83	2,377,059,790.50
12	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,442,742,959.83	2,377,059,790.50
120	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	2,442,742,959.83	2,377,059,790.50
120013	1.1.1.1.04.1.10 Бараа борлуулсан, үйлчилгээ	2,442,742,959.83	2,377,059,790.50

Говь-Алтай аймгийн “Ундарга-Алтай” аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2025 оны  
санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

	үзүүлсний орлого /ТӨҮГ/		
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,324,565,715.83	2,419,859,295.40
21	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	2,324,565,715.83	2,419,859,295.40
210	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,324,565,715.83	2,419,859,295.40
2101	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	906,195,245.33	1,297,913,205.69
210106	1.1.1.2.01.1.01.06 Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	906,195,245.33	1,297,913,205.69
2102	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	247,571,047.24	-
210206	1.1.1.2.01.1.02.06 Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	247,571,047.24	-
2103	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	472,905,829.67	302,132,869.77
210305	1.1.1.2.01.1.03.05 Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	472,905,829.67	302,132,869.77
2104	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	331,364,779.26	397,882,291.64
210409	1.1.1.2.01.1.04.07 Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	59,284,000.00	76,986,131.64
210410	1.1.1.2.01.1.04.08 Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	272,080,779.26	320,896,160.00
2108	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	366,528,814.33	421,930,928.30
210816	1.1.1.2.01.1.08.11 Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	289,105,955.22	261,488,749.42
210817	1.1.1.2.01.1.08.12 Даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	-	5,590,800.00
210818	1.1.1.2.01.1.08.13 Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	77,422,859.11	154,851,378.88
III	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	118,177,244.00	(42,799,504.90)
V	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	53,586,234.74	-
22	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	53,586,234.74	-
2200	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	53,586,234.74	-
225106	1.1.2.2.01.1.06 Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	53,586,234.74	-
VI	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(53,586,234.74)	-
VIII	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	64,591,009.26	(42,799,504.90)
101	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,320,374.19	67,911,383.45
20	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	67,911,383.45	25,111,878.55

**2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

**(төгрөгөөр)**

Дансны код	Дансны нэр, төрөл	1.1 Засгийн газрын оруулсан капитал	1.2 Дахин үнэлгээний нөөц	1.3 Хуримтлагдсан үр дүн	1.4 Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,413,450,457.62	59,760,414.97	(1,398,766,723.48)	2,074,444,149.11
3	1.1.1.1.1 Дахин	3,413,450,457.62	59,760,414.97	(1,398,766,723.48)	2,074,444,149.11

Говь-Алтай аймгийн “Ундарга-Алтай” аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

	илэрхийлсэн үлдэгдэл				
9	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	-	-	206,133,260.16	206,133,260.16
10	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,413,450,457.62	59,760,414.97	(1,192,633,463.32)	2,280,577,409.27
11	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,413,450,457.62	59,760,414.97	(1,192,633,463.32)	2,280,577,409.27
13	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,413,450,457.62	59,760,414.97	(1,192,633,463.32)	2,280,577,409.27
19	1.7 Тайлант үеийн үр дүн	-	-	(588,447,201.51)	(588,447,201.51)
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,413,450,457.62	59,760,414.97	(1,781,080,664.83)	1,692,130,207.76

**2.5 Аудит хийсэн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлийн тайлан**

( төгрөгөөр)

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Үйл ажиллагааны орлого	4,049,957,660.00	2,523,654,615.89	1,526,303,044.11	62.3
<b>ОРЛОГО</b>	<b>4,049,957,660.00</b>	<b>2,523,654,615.89</b>	<b>1,526,303,044.11</b>	<b>62.3</b>
1.2 Борлуулсан бүтээгдэхүүний өртөг			-	
<b>1.3 Нийт ашиг</b>	<b>4,049,957,660.00</b>	<b>2,523,654,615.89</b>	<b>1,526,303,044.11</b>	<b>62.3</b>
Үндсэн үйл ажиллагаа				
Цалин	1,577,680,608.00	1,157,046,879.53	420,633,728.47	73.3
Байгууллага төлөх НДШ	222,343,516.32	117,669,071.73	104,674,444.59	52.9
Бичиг хэрэг	25,295,500.00	23,363,954.59	1,931,545.41	92.4
Харилцаа холбоо	23,361,600.00	18,396,092.60	4,965,507.40	78.7
Сургалтын зардал	30,600,000.00	28,212,000.00	2,388,000.00	92.2
Сэлбэг багаж хэрэгсэл	67,575,000.00	61,497,727.27	6,077,272.73	91.0
Хөдөлмөр хамгаалал	69,212,000.00	60,097,363.63	9,114,636.37	86.8
Шатахуун	71,400,000.00	76,986,131.64	(5,586,131.64)	107.8
Ариутгалын бодис	51,000,000.00	45,968,000.00	5,032,000.00	90.1
Зээлийн хүүгийн төлбөр	256,000,000.00	169,485,400.48	86,514,599.52	66.2
Цахилгааны зардал	810,768,000.00	768,730,039.96	42,037,960.04	94.8
Дулааны зардал	71,870,400.00		71,870,400.00	0.0
Зар сурталчилгааны зардал	2,000,000.00	1,062,000.00	938,000.00	53.1
Гамшгийн зардал	11,325,000.00	-	11,325,000.00	0.0
Засвар үйлчилгээний зардал	233,194,000.00	239,800,000.00	(6,606,000.00)	102.8
Элэгдэл хорогдлын зардал	400,000,000.00	283,989,527.70	116,010,472.30	71.0
Ажилчдын нийгмийн зардал	51,080,000.00	48,512,000.00	2,568,000.00	95.0
Татвар даатгалын зардал	37,420,000.00	11,285,628.36	26,134,371.64	30.2
Нууцын зардал	23,500,000.00		23,500,000.00	0.0
<b>1.4.20 Үйл ажиллагааны</b>	<b>4,035,625,624.32</b>	<b>3,112,101,817.49</b>	<b>923,523,806.83</b>	<b>77.1</b>

зардлын дүн				
1.5 Үндсэн үйл ажиллагааны ашиг /алдагдал/	14,332,035.68	(588,447,201.60)	602,779,237.28	
Үндсэн бус үйл ажиллагаа			-	
Татвар төлөх ашиг алдагдал	14,332,035.68	(588,447,201.60)	602,779,237.28	

### Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар 1,232,124.0 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

#### 3.1 Залруулсан алдаа:

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Санхүүгийн байдлын тайланд тусгай зориулалттай материалыг 2.2 мянган төгрөгөөр, бэлэн бүтээгдэхүүнийг 10,192.1 мянган төгрөгөөр, сэлбэг хэрэгслийг 9,264.4 мянган төгрөгөөр, бусад хангамжийн материалыг 96,881.3 мянган төгрөгөөр тус тус дутуу, бусад хангамжийн материалыг 116,340.0 мянган төгрөгөөр илүү,
- Орлогын дэлгэрэнгүй тайланд бусад орлогыг 6,864.0 мянган төгрөгөөр, бусад зардлыг 2,816.0 мянган төгрөгөөр, хөрөнгө оруулалтын гарзыг 3,286.2 мянган төгрөгөөр, нийт үр дүнг 719,434.0 мянган төгрөгөөр тус тус дутуу, борлуулалтын орлогыг 6,862.0 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олзыг 2,0 мянган төгрөгөөр, Ерөнхий ба удирдлагын зардлыг 718,963.8 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны бус үр дүнг 3,284.2 мянган төгрөгөөр тус тус илүү,
- Мөнгөн гүйлгээний тайланд эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлогыг 1,100.0 мянган төгрөгөөр, их засварын зардлыг 4,711.0 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн зардлыг 16,500.0 мянган төгрөгөөр, нийт цэвэр мөнгөн гүйлгээг 705.9 мянган төгрөгөөр тус тус илүү, бусад орлогыг 1,100.0 мянган төгрөгөөр, бусад зардлыг 21,917.0 мянган төгрөгөөр тус тус илүү тайлагнасныг залруулсан.
- **Мэдээллийг орхигдуулсантай холбоотой:** Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 1,881,852.1 мянган төгрөгийн 226 мэдээллээс бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээ нийт 360,366.9 мянган төгрөгийн 90 мэдээллийг тус тус мэдээлээгүйг нөхөн байршууллаа.

Аудитаар залруулагдаагүй нийт 1,686,993.6 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 1,686,993.6 мянган төгрөгийн 9 зөрчил<sup>2</sup> илэрч 1 төлбөрийн акт, зөрчил арилгах, давтан гаргахгүй байх 3 албан шаардлага, 3 зөвлөмж, 2 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 3.2 Төлбөрийн акт

Нэг. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж, тайлант оны зорилтот түвшинд батлаагүй байхад байгууллагын төсвөөс баруун бүсийн ажил мэргэжлийн уралдаан, тэмцээн, зөвлөгөөнд 1,752.0 мянган төгрөг, ажилчдын баярт 2,324.0 мянган төгрөг нийт 4,076.0 мянган төгрөгийг бэлэг дурсгалын зүйлд зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "Хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-т "Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин зарцуулсан 4,076.0 мянган төгрөгийг Төрийн сан дахь Га.Аудитын орлогын 100050000982 тоот дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт хүргүүлсэн.

### 3.3 Албан шаардлага

Нэг. Санхүүгийн тайланд тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байгууллага, хувь хүнтэй холбоотой 1,059,765.3 мянган төгрөгийн авлага, 241,966.3 мянган төгрөгийн өр төлбөр тусгасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1-т "Өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах"; 20 дугаар зүйлийн 20.1.2-т "Үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах", Ундарга-Алтай аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2025 оны батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн төлөвлөгөө" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага, өглөгийг тооцоог нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилган, бууруулах албан шаардлага хүргүүлсэн.

Хоёр. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор 214,325.0 мянган төгрөгийн 5 үндсэн хөрөнгийг актлах шийдвэр гарсан боловч 7,856.4 мянган төгрөгийн 1 хөрөнгийг актлаагүй нь Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 33 дугаар тогтоолын хавсралт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 22 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, данснаас хасах, тайлагнах журам" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолоор баталсан хөрөнгийг актлах, данснаас хасах албан шаардлага хүргүүлсэн.

Гурав. Тайлант онд гэрээгээр хийгдсэн 211,999.1 мянган төгрөгийн 8 ажлын гүйцэтгэлийг хүлээн авсан боловч, хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 41

дүгээр зүйлийн 41.2.7-т "Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-т "Төрийн өмчийн эд хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан журмаар үнэлж бүртгэнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Дөрөв. Тус байгууллага жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаанд нь төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй, жилийн эцсийн тооллого хийх ажлын хэсгийг томилоогүй, Ундарга-Алтай аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2022, 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 06/250, 01/104 дугаартай 17,108.3 мянган төгрөгийн шүүхийн шийдвэрээр олгосон цалингийн нөхөн олговортой холбоотой 2 албан шаардлагыг төлүүлэх арга хэмжээ аваагүй, тайланд 1-с дээш жилийн насжилттай он дамнасан авлагыг барагдуулах талаар арга хэмжээ аваагүй, тайлант онд 13,299.0 мянган төгрөгийн тавилга, багаж бэлтгэсэн боловч цахим дэлгүүрээс худалдан аваагүй зэрэг зөрчлийг давтан гаргасан, 1,243,906.1 мянган төгрөгийн авлага, 4,775,449.1 мянган төгрөгийн өр төлбөртэй ажилласан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана", 72 дугаар зүйлийн 72.1-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь тооллого эхлэхээс өмнө өмч хамгаалалтад хяналт тавих үүрэг бүхий болон холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан Тооллогын комисс томилж байгуулна", Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-т "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх", "Ундарга-Алтай" ААТҮГ-ын дүрмийн 11.1-т "Газар нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна. Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг үйлдвэрийн газрын Гүйцэтгэх захирал хариуцна", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын байгууллагаас өгсөн аудитын шийдвэрийг биелүүлээгүй, албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн Говь-Алтай аймгийн Ундарга-Алтай аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал Э.Энхболд, нягтлан бодогч М.Мөнхбаатар нарт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах.

### **3.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **Нэг. Төсвийн зарцуулалттай холбоотой**

Илрүүлэлт: Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшний төлөвлөгөөнд тусгаагүй 10,000.0 мянган төгрөгийн тавилга бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 32 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшний төлөвлөгөөнд тусгаагүй хөрөнгө худалдан авахгүй байх.

Илрүүлэлт: Борлуулалтын орлогыг аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан, нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд 714,774.8 мянган төгрөгөөр, орлого, үр дүнгийн тайланд 149,872.9 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-т "суутгасан татварыг хуульд заасан хугацаанд харьяа татварын албанд үнэн зөв тайлагнах" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Борлуулалтын орлогыг тайланд зөрүүгүй тайлагнаж байх.

Илрүүлэлт: Байгууллагын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөнд 4,049,957.7 мянган төгрөгийн борлуулалтын орлого төлөвлөсөн боловч 1,526,335.8 мянган төгрөгийн орлого тасарч, 588,447.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх"; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-т "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" заалттай нийцэхгүй, санхүүгийн

тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Байгууллагын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг ханган ажиллах арга хэмжээг авах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Ундарга-Алтай аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар	Санхүүгийн байдлын тайланд тусгай зориулалттай материалыг 2.2 мянган төгрөгөөр, бэлэн бүтээгдэхүүнийг 10,192.1 мянган төгрөгөөр, сэлбэг хэрэгслийг 9,264.4 мянган төгрөгөөр, бусад хангамжийн материалыг 96,881.3 мянган төгрөгөөр тус тус дутуу,бусад хангамжийн материалыг 116,340.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.	1	116,340.0	-	-	1	116,340.0	1	116,340.0	-	-	-	-
	Орлогын дэлгэрэнгүй тайланд бусад орлогыг 6,864.0 мянган төгрөгөөр, бусад зардлыг 2,816.0 мянган төгрөгөөр, хөрөнгө оруулалтын гарзыг 3,286.2 мянган төгрөгөөр, нийт үр дүнг 719,434.0 мянган төгрөгөөр тус тус дутуу, борлуулалтын орлогыг 6,862.0 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олзыг 2,0 мянган төгрөгөөр, Ерөнхий ба удирдлагын зардлыг 718,963.8 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны бус үр дүнг 3,284.2 мянган төгрөгөөр тус тус илүү тайлагнасан.	1	732,400.2	-	-	1	732,400.2	1	732,400.2	-	-	-	-
	Мөнгөн гүйлгээний тайланд эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлогыг 1,100.0 мянган төгрөгөөр, их засварын зардлыг 4,711.0 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн зардлыг 16,500.0 мянган төгрөгөөр, нийт цэвэр мөнгөн гүйлгээг 705.9 мянган төгрөгөөр тус тус илүү, бусад орлогыг 1,100.0	1	23,016.9	-	-	1	23,016.9	1	23,016.9	-	-	-	-

Говь-Алтай аймгийн “Ундарга-Алтай” аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2025 оны  
санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

	мянган төгрөгөөр, бусад зардлыг 21,917.0 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан байна.												
	Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 1,881,852.1 мянган төгрөгийн 226 мэдээллээс бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээ нийт 360,366.9 мянган төгрөгийн 90 мэдээллийг мэдээлээгүй байна.	1	360,366.9	1	360,366.9	-	-	1	360,366.9	-	-	-	-
	<b>Дүн</b>	<b>4</b>	<b>1,232,124.0</b>	<b>1</b>	<b>360,366.9</b>	<b>3</b>	<b>871,757.1</b>	<b>4</b>	<b>1,232,124.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Ундарга-Алтай аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж, тайлант оны зорилтот түвшинд батлаагүй байхад байгууллагын төсвөөс баруун бүсийн ажил мэргэжлийн уралдаан, тэмцээн, зөвлөгөөнд 1,752.0 мянган төгрөг, ажилчдын баярт 2,324.0 мянган төгрөг нийт 4,076.0 мянган төгрөгийг бэлэг дурсгалын зүйлд зарцуулсан байна.	1	4,076.0	1	4,076.0	-	-	-	-	-	-	-
	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшний төлөвлөгөөнд тусгаагүй 10,000.0 мянган төгрөгийн тавилга бэлтгэсэн байна.	1	10,000.0	-	-	-	-	-	1	10,000.0	-	-
	Борлуулалтын орлогыг аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан, нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд 714,774.8 мянган төгрөгөөр, орлого, үр дүнгийн тайланд 149,840.1 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан байна.	1	864,614.9	-	-	-	-	-	1	864,614.9	-	-
	Байгууллагын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшиний төлөвлөгөөнд 4,049,957.7 мянган төгрөгийн борлуулалтын орлого төлөвлөсөн боловч 1,526,335.8 мянган төгрөгийн орлого тасарч, 453,022.0 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.	1	453,022.0	-	-	-	-	-	1	453,022.0	-	-
	Санхүүгийн тайланд тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байгууллага, хувь хүнтэй холбоотой 1,059,765.3 мянган төгрөгийн авлага, 241,966.3 мянган төгрөгийн өр төлбөр тусгасан байна.	1	-	-	-	-	1	-	-	-	-	-

Говь-Алтай аймгийн “Ундарга-Алтай” аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2025 оны  
санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор 214,325.0 мянган төгрөгийн 5 үндсэн хөрөнгийг актлах шийдвэр гарсан боловч 7,856.4 мянган төгрөгийн 1 хөрөнгийг актлаагүй байна.	1	7,856.4	-	-	1	7,856.4	-	-	-	-
	Тайлант онд гэрээгээр хийгдсэн 211,999.1 мянган төгрөгийн ажлуудын гүйцэтгэлийг хүлээн авсан боловч, хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.	1	211,999.1	-	-	1	211,999.1	-	-	-	-
	Тус байгууллага жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаанд нь төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй, жилийн эцсийн тооллого хийх ажлын хэсгийг томилоогүй, Ундарга-Алтай аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2022, 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 06/250, 01/104 дугаартай 17,108.3 мянган төгрөгийн шүүхийн шийдвэрээр олгосон цалингийн нөхөн олговортой холбоотой 2 албан шаардлагыг төлүүлэх арга хэмжээ аваагүй, тайланд 1-с дээш жилийн насжилттай он дамнасан авлагыг барагдуулах талаар арга хэмжээ аваагүй, тайлант онд 13,299.0 мянган төгрөгийн тавилга, багаж бэлтгэсэн боловч цахим дэлгүүрээс худалдан аваагүй зэрэг зөрчлийг давтан гаргасан, 1,243,816.4 мянган төгрөгийн авлага, 4,655,072.3 мянган төгрөгийн өр төлбөртэй ажилласан байна.	2	-	-	-	-	-	-	-	2	-
	<b>Дүн</b>	<b>9</b>	<b>1,551,568.4</b>	<b>1</b>	<b>4,076.0</b>	<b>3</b>	<b>219,855.5</b>	<b>3</b>	<b>1,327,636.9</b>	<b>2</b>	<b>-</b>

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТБОНӨГ		1				1		
	<b>НИЙТ</b>		<b>1</b>				<b>1</b>		